



БАЯНХОНГОР АЙМГИЙН  
ӨЛЗИЙТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2022 оны 04 сарын 06 өдөр

Дугаар А/42

Улаан-Уул

Ой, хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх талаар авах зарим арга хэмжээний тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.1, Ойн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.2.2, Улсын онцгой комиссын 2022 оны “Ой, хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх, тэмцэх зарим арга хэмжээний тухай” 01 дүгээр албан даалгавар, аймгийн Засаг даргын 2022 оны 02 дугаар сарын 21-ний өдрийн А/90 дүгээр захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Сумын хэмжээнд ойн сан бүхий газарт ой, хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх зорилгоор 2022 оны 04 сарын 11-ний өдрөөс 2022 оны 06 сарын 10-ны өдрийг хүртэл, 2022 оны 09 сарын 20-ны өдрөөс 2022 оны 11 сарын 10-ны өдрийг хүртэл иргэдийн аялал зугаалга, байгалийн дагалт нөөц баялгийг ашиглах зорилгоор үйлдэх хөдөлгөөнийг түр хугацаагаар хориглосугай.

2. Сумын гамшгаас хамгаалах төлөвлөгөөнд тодотгол хийж ой, хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх төлөвлөгөө гарган батлуулахыг Тамгын газрын дарга (М.Зоригт), Байгаль орчны хяналтын улсын байцаагч (Т.Мөнхжаргал)-д даалгасугай.

3. Ой, хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх зорилгоор багийн нутаг дэвгэрийн хяналтын цэгт морьт эргүүл гарган томилгоожуулан ажиллахыг 3-дугаар багийн Засаг дарга (Г.Батжаргал), 4 дүгээр багийн Засаг дарга (Р.Эрдэнэбат), 5 дугаар багийн Засаг дарга (Э.Гонгор) нарт тус тус үүрэг болгосугай.

4. Төлөвлөгөөний хэрэгжилтийг ханган тогтоосон хугацаанд биелэлтийг гарган аймгийн Онцгой байдлын газарт хүргүүлж ажиллахыг Засаг даргын орлогч (Г.Баттогтох)-д үүрэг болгосугай.

ДАРГА Т.ЭРДЭНЭБАТ

642201059